



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2024 оны 06 сарын 19 өдөр

Дугаар А/447

Булган сум

**Үнэлгээний хороо байгуулах тухай**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21, 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.2.2, 50 дугаар зүйлийн 50.5 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны 2023 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн XIX/08 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Байгаль хамгаалах сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих Алтаргана наадмын үеэр ашиглагдах нийтийн эко жорлон барих ажлыг гүйцэтгэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Үнэлгээний хорооны

дарга: Б.Баярцэнгэл (Худалдан авах ажиллагааны газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Гишүүд: Г.Бямбажаргал (Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн)  
Ё.Хулан (Нийгмийн бодлогын хэлтсийн мэргэжилтэн)

Иргэний төлөөлөл: О.Буянбат (Булган сумын иргэн)

Нарийн бичгийн дарга: А.Гэрэл (Худалдан авах ажиллагааны газрын мэргэжилтэн)

2. Худалдан авах ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулахыг үнэлгээний хороо (Б.Баярцэнгэл)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Б.АРИУН-ЭРДЭНЭ



6324010586